Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архуст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардал 1,627,648.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 24,414.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,531.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас 1,5 хувиар буюу 26,854.9 мянган төгрөгөөр тогтоосон ба төлөвлөлтийн үе шатнаас 2,440.2 мянган төгрөгөөр өссөн. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 21,483.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Архуст сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангаар аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 476,979.6 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 988,421.3 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 13,296.2 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 67,484.9 мянган төгрөгийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 197,045.1 мянган төгрөг, эмийн эргэлтийн сангийн борлуулалтын орлого 71,742.1 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргэлтийн барьцаа сангийн орлого 2,085.0 мянган төгрөг, соёлын төвийн орлого 8.8 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 157,225.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 208,018.0 мянган төгрөг нийт 2,182,306.3 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Архуст сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 13 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 50,839.9 мянган төгрөг, татварын бус орлогыг 5,100.0 мянган төгрөг, нийт 55,939.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 68,837.1 мянган төгрөг, татварын бус орлого 139,180.9 мянган төгрөг, нийт 208,018.0 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 152,078.1 мянган төгрөг буюу 3.72 дахин биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд сумын Засаг даргатай байгуулсан Идлэг шонхор шувуу бариулах тухай гэрээний дагуу 136,512.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 4,462.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,288,707.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 1,293,170.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 29,886.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 349,357.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 10,824.3 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 30,253.5 мянган төгрөгийн, нийт 390,435.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 382,099.8 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 70,973.4 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 239,875.7 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 10,530.2 мянган төгрөг, нийт 321,379.3 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 249,785.4 мянган төгрөг буюу 77.8 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 168.2 мянган төгрөг, байгууллагад төлөх 6,092.6 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 422.0 мянган төгрөг, нийт 6,682.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өглөгийн 4,800.0 мянган төгрөгийг ОНХС-ийн, 2,085.0 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн, 1,292.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн, 422.0 мянган төгрөгийг ИТХ-ын өр эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 257,151.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 78.1 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 10,533.7 мянган төгрөг, байгууллагын касс 21.4 мянган төгрөг, нийт 267,784.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 249,589.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,850,550.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,381.2	267,784.5	242,403.3
Авлага	314,388.8	321,379.3	6,990.5
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	241,254.6	249,589.8	8,335.2
Үндсэн хөрөнгө	2,738,733.4	3,850,550.6	1,111,817.2
Нийт хөрөнгө	3,319,758.0	4,689,304.2	1,369,546.2
Өр төлбөр	3,977.6	6,682.8	2,705.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,315,780.4	4,682,621.4	1,366,841.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,319,758.0	4,689,304.2	1,369,546.2

Бараа материалын дансны үлдэгдэл 249,589.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 8,335.2 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,850,550.6 мянган төгрөг болж 1,111,817.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЗДТГ-ын барилга аймгийн төсвийн 495,724.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар, ЕБС-ийн дотуур байрны барилга улсын төсвийн 700,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 92,983.6 мянган төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг дансанд бүртгэлд тусган, тайлагнаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,682,621.4 мянган төгрөг болж 1,366,841.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,554,355.6 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Архуст сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 55,939.9 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 1,578,782.4 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 13 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,576,753.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 150,000.0 мянган төгрөгөөр, нийт 1,726,753.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 172,98.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 8 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,547,813.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 67,484.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 150,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,765,298.0 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор төлөвлөгөө нийт 1,726,753.6 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЗДТГ 13,176.1 мянган төгрөгөөр илүү, СӨБ 14,834.2 мянган төгрөгөөр дутуу, ЕБС 5,224.9 мянган төгрөгөөр илүү, Эрүүл мэндийн төв 34,977.6 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй байна.

Нийт зардлын 988,421.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 532,919.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 13,296.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 67,484.9 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 150,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,495,450.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 33,100.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 149,571.9 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,678,122.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 41,515.2 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 10,716.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,678,122.6 мянган төгрөг буюу 95,1 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 157,225.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 79,264.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 72,603.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 3,349.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,929.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 78.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Архуст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгч, 39,246.5 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 43,903.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 579.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа Уул аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сангийн 4 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн ба ЕБС-ийн санхүүгийн тайланд 708,766.0 мянган төгрөгийн залруулга хийж, 710.9 мянган төгрөгийн

7 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 38,876.3 мянган төгрөгийн залруулга хийж, 600.0 мянган төгрөгийн 7 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 265,102.6 мянган төгрөгийн залруулга хийж, 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Архуст сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 13 дугаар тогтоолоор тодотгон баталсан 1,726,753.6 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,765,298.0 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЗДТГ 13,176.1 мянган төгрөгөөр илүү, СӨБ 14,834.2 мянган төгрөгөөр дутуу, ЕБС 5,224.9 мянган төгрөгөөр илүү, Эрүүл мэндийн төв 34,977.6 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ 3,432.1 мянган төгрөг, Соёлын төв 155.3 мянган төгрөг, ЕБС 162.2 мянган төгрөг, Цэцэрлэг 38.5 мянган төгрөгөөр тус тус илүү, ЗДТГ 476.1 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна. Орон нутгийн татварын орлогын тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 36, огт байршуулаагүй 12 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 31,6 хувийг эзэлж байна. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл хэсгийг огт байршуулаагүй ба хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн 05/111 дугаар албан бичгээр ирүүлсэн ба шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг таслан зогсоосон эсэхэд дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 106,317.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,398.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,577.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 48,658.7 мянган төгрөгийн албан шаардлага, 47,682.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Соёлын төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн 313.9 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг болон ОНХС-гийн эх үүсвэрээр бэлтгэсэн 4,000.0 мянган төгрөгийн гэрэлтүүлгийг бусад хангамжийн материал дансанд буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд тайлант хугацаанд төвлөрсөн 2,085.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Архуст сумын ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "урамшуулал олгох тухай" 14 дүгээр захирамжаар 2021 оны 12 дугаар сарын 01-нд байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн ЗДТГ-ын архив бичгийн хэргийн ажилтан С.Цэрэндуламд 350.0 мянган төгрөг, Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

Б.Мөнгөнзагасд 450.0 мянган төгрөгийн урамшууллыг, ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр захирамжаар үйлчлэгч Н.Ууганбаярт 280.0 мянган төгрөг, нийт 1,080.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргад ИТХ-ийн даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 09 дүгээр захирамжаар 4 дүгээр улирлын үр дүнгийн гэрээний урамшууллыг 40 хувиар олгосон ба давхардуулан ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 19 дүгээр захирамжаар 40 хувиар буюу 418.2 мянган төгрөгийн урамшуулал, ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 18 дугаар захирамжаар сумын ХЭАХН-ийн салбар зөвлөлийн даргын ажлыг хавсран гүйцэтгэсэн гэж урамшуулалд 20 хувийг 2021 оны 4 дүгээр сараас буюу 1,440.9 мянган төгрөг, нийт 1,859.1 мянган төгрөгийг 2021 оны 12 дугаар сард олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Сумын ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” 20 дугаар захирамжаар нягтлан бодогч Б.Мөнхгэрэлд 1 дүгээр хагас жилийн урамшуулалд 40%, ИТХ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” 13 дугаар захирамжаар 2021 оны үр дүнгийн гэрээний

урамшууллыг 40 хувиар буюу 638.1 мянган төгрөг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр бууны албан татвар төлөвлөгөө 260.0 мянган төгрөгөөр буюу 29,2 хувиар, газрын төлбөрийн орлого 6,061.6 мянган төгрөг буюу 42,2 хувиар, хүү торгуулийн орлого 1,480.5 мянган төгрөг буюу 37,0 хувиар, түрээсийн орлого 1,000.0 мянган төгрөгөөр буюу 100 хувь тасарсан, нийт 4 нэр төрлийн орлого 8,802.1 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 39,856.6 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг

тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Татварын мэдээ гаргалттай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлого 208,018.0 мянган төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн мэдээгээр 207,581.8 мянган төгрөг буюу 436.2 мянган төгрөгөөр, сумын татварын байцаагч 145.4 мянган төгрөгөөр зөрүүтэй. Нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлого, тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, хүү торгууль зэрэг 4 нэр төрлийн орлогын дүнг зөрүүтэй мэдээлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

2. *Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан 1,726,753.6 мянган төгрөгийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн тайланд 38,544.4 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу сумын ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЗДТГ 13,176.1 мянган төгрөг, СӨБ 14,834.2 мянган төгрөгөөр илүү, ЕБС 5,224.9 мянган төгрөгөөр, ЭМТ 34,977.6 мянган төгрөгөөр тус тус дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогыг үнэн зөв баталж, хяналт тавьж ажиллах

3. *Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 8,556,8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

4. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 36, огт байршуулаагүй 12 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 31,6 хувийг эзэлж байна. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл хэсгийг огт байршуулаагүй ба хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам", санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Засаг дарга	11	106,317.6	2	6,398.9	3	3,577.2	2	48,658.7	4	47,682.8
2	ЗДТГ	7	83,729.1	2	39,246.5			3	43,562.8	2	919.8
3	ЕБС	7	710.9	3	708,766.0					7	710.9
4	СӨБ	7	600.0	1	38,876.3					7	600.0
5	ЭМТ	3	0	3	265,102.6					3	0
	НИЙТ	42	1,204,102.5	11	1,058,390.3	3	3,577.2	5	92,221.5	23	49,913.5

